

АГУУЛГА

ОРШИЛ.....	3
I. ТӨСЛИЙН ЗОРИЛГО, ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН	4
I.1. Төслийн зорилго.	4
I.2. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгжийн танилцуулга.....	4
I.3. Ордын нөөц.	4
I.4. Уурхайн техник, тоног төхөөрөмжийн хувьд.....	4
I.5. Хүний нөөц.....	4
II. ТӨСЛИЙН ТАЛБАЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	5
II.1. Ордын байршил.	5
II.2. Бүс нутгийн физик газар зүйн мэдээлэл	5
II.3. Геологийн тогтоц	6
II.4. Ордын тектоник.....	7
II.5. Ордын геологийн тогтоц, нүүрсний чанар.....	8
II.6. Ордын нөөцийн тооцоо.....	8
БҮЛЭГ-III. ИЛ УУРХАЙН ТӨЛӨВЛӨЛТ	9
III.1. Уурхайн өнөөгийн байдал.....	9
III.2. Уулын ажил.....	12
III.3. Ил уурхайн механикжуулалт үндсэн тоног төхөөрөмж.....	13
III.4. Ил уурхайн ажиллах горим.....	13
IV. ХОГ ХАЯГДАЛ	17
V. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ.....	18
V.1. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	19
V.2. Агаарын чанарт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл.....	19
V.3. Усны нөөц, чанарт гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга	19
V.4. Газрын хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл	20
V.5. Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл	20
V.6. Ургамлын аймаг, ургамлын нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл.....	20
V.7. Амьтны аймагт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл.....	20
VI. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ	21
VI.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	23
VI.2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	24
VI.3. Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ төлөвлөгөө	25
VI.4. Ургамлын аймаг, ургамлын нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	25
VI.5. Амьтны аймагт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө ..	26
VII. Биологийн нөхөн сэргээлт-мод тарилт.....	27
VII.1.1. Мод тарихын экологийн ач холбогдол.....	28
VII.1.2. Мод, сөөг болон түүний бүтэц, зарим үүрэг.....	28
VII.1.3. Тарих тарих хугацаа.....	28
VII.1.4. Мод тарьсан аргачлал	29
VII.1.5. Мод суулгасныг дараах арчилгаа.....	30
VII.1.6 Техникийн сэргээлтийн төлөвлөгөө	31
VIII. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ	32
IX. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	34

Х. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	34
XI. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	35
XII. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	36
XII.1 Хог хаягдлыг бууруулах, дахин ашиглах, боловсруулах	37
XII.2. Ахуйн хог хаягдал.....	38
XII.3. Аюултай хог хаягдал-техникийн тос.....	38
XII.4. Бусад аюултай хог хаягдлыг хадгалах	39
XIII. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ	42
XIII.1. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	42
XIV. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	44
XIV.1. БОМТ-ний төсвийн нэгтгэл	44

ХҮСНЭГТ

Хүснэгт № 1. Тусгай зөвшөөрлийн талбайн газар зүйн дараах солбицлууд.....	5
Хүснэгт 2. Нүүрсний үлдэгдэл нөөц	9
Хүснэгт 3. Ил уурхайд ажиллах үндсэн болон туслах тоног төхөөрөмжүүд.....	13
Хүснэгт 4. Уурхайн ажлын горим	14
Хүснэгт 5. Агаарын чанарын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	23
Хүснэгт 6. Усны нөөцөд учруулж болзошгүй сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	24
Хүснэгт 7. Газрын хэвлий, хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд	25
Хүснэгт 8. Ургамлын аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	25
Хүснэгт 9. Амьтны аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	26
Хүснэгт 10. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, хэрэгжилт.....	32
Хүснэгт 11. Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө.....	34
Хүснэгт 12. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	34
Хүснэгт 13. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	35
Хүснэгт 14. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	36
Хүснэгт 15. 2023 оны хог хаягдлын эх үүсвэрийн тооллогын хуудас	40
Хүснэгт 16. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилт	42
Хүснэгт 17. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний төсвийн нэгтгэл ...	44

ОРШИЛ

“Бэрх уул” ХК нь Хэнтий аймгийн Мөрөн сумын нутагт орших 43,75 гектар талбай бүхий, MV-004590 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Чандган тал нүүрсний ордыг эзэмшдэг.

Чандган тал нүүрсний ордыг ордын уул геологийн нөхцөл, элсний биетийн хэлбэр ба байршил, хучаас хөрсний зузаан зэрэгт үндэслэн ордыг ил уурхайн аргаар, авто тээвэртэй гадаад болон дотоод овоолготой, ашиглалтын системээр ашиглахаар ТЭЗҮ-ийг 2023 онд ордыг ил уурхайн аргаар, авто тээвэртэй гадаад болон дотоод овоолготой, ашиглалтын системээр ашиглахаар боловсруулсан.

2024 онд нийт 30.7 мян.тн нүүрс олборлож, 47.93 мян.м³ хөрс хуулсан байна. Хөрс хуулалтын дундаж коэффициент 4.52 м³/тн байна.

Уурхайн гүнзгийрэл уурхайн эцсийн хүрэн дэх нүүрсний нөөцийг бүрэн олборлох хүртэл ашиглалтын талбайд техникийн нөхөн сэргээлт хийхгүй бөгөөд 2024 онд биологийн нөхөн сэргээлтэд 2000 ш мод уурхайн тосгонд тарьсан байна.

Орон нутгийн санал болгосны дагуу дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд ашиглалтын талбайн гадна 3 га талбайд байрлах малын сэг зэм, хог хаягдлыг цэвэрлэн эзэн холбогдоггүй эвдэрсэн газарт техникийн нөхөн сэргээлт хийхсэн.

Манай компани нь БОАЖ сайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А-618 дугаар тушаалаар батлагдсан журмын, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг үндэслэн энэхүү 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсруулав.

Компани нь байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэй үйл ажиллагаа явуулахын тулд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, нэгэнт болсон сөрөг нөлөөллийг арилгах, болсны дараа арга хэмжээ авах гэсэн дараалал баримтлах бөгөөд төсөл хэрэгжих нутгийн иргэд болон сонирхогч талуудад төслийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод байлгах зарчим баримтлан ажиллалаа.

I. ТӨСЛИЙН ЗОРИЛГО, ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

I.1. Төслийн зорилго.

Чандган тал хүрэн нүүрсний ордыг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль, дүрэм журам, стандартын дагуу үйл ажиллагааг явуулж, эдийн засгийн хувьд үр ашигтайгаар, байгалийн баялгийг зохистой ашиглаж, дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх, технологийн горимыг нарийн чанд баримталж, байгаль орчныг хамгаалж, нөхөн сэргээлт хийх, шинээр ажлын байр бий болгох, мөн компанийн ажилчид болон олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, ордын үр ашгийг улс, орон нутаг болон төсөл хэрэгжүүлэгч компанид хүртээхэд уг төслийн зорилго оршино.

I.2. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгжийн танилцуулга.

“Бэрх-Уул” ХК нь 1954 онд үүсгэн байгуулагдсан ба ил уурхайн ашиглалт үйл ажиллагааг хэвийн гүйцэтгэж ирсэн туршлагатай. Төсөл хэрэгжүүлэгч нь 2010 оны 01-р сарын 04-ний өдөр 1810002001 улсын бүртгэлийн дугаартай 2643928 регистрийн дугаартай уул уурхайн олборлолт гэсэн үндсэн үйл ажиллагааны чиглэлтэй үүсгэн байгуулагдсан. “Бэрх-Уул” ХК нь орон нутгийн өмчит хувьцаат компани буюу Khanate Resource Holding– 51.8%, Khanate Resource Holdings-2 SARL – 31.2%, BEU Holding S.A.R.L -10%, Khanate Resource Holding-3 SARL-6.6%, иргэд нийт хувьцааны – 0.4% – ийг тус тус эзэмшиж байна. Албан ёсны хаяг: Хэнтий аймаг, Бэрх тосгон (Батноров сум), Уулын үйлдвэрийн байр-01 байрлана.

I.3. Ордын нөөц.

Улсын төсвийн хөрөнгөөр Чандган талын нүүрсний орд газарт 1963 онд геологийн нарийвчилсан хайгуул хийж тус ордын нөөцийг А+В+С1 зэрэглэлээр 123,845.0 мян.тн (А-13,036.0 мян.тн, В-37,632.0 мян.тн, С1-72,177.0 мян.тн), С2 зэрэглэлээр 90,139.0 мян.тн гэж тус тус тооцож, улсын нөөцөд бүртгүүлсэн байна.

Өнөөгийн байдлаар тус орд дээр “Бэрх-Уул” ХК, “Чандганкоул” ХХК, “Тефис Майнинг” ХХК гэсэн 3-н компани ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа болно.

Дээрх гурван компани нөөцийн хөдөлгөөний тайлангаар “Бэрх-Уул” ХК -ны тусгай зөвшөөрийн талбайд А+В+С1 зэргээр 21,278,9 мян.тн нүүрс байна.

Бэрх-Уул компани 2024 оны уулын ажлын тайнгийн үлдэгдэл нөөц А+В+С1 зэргээр 20490.82 мян.тн нүүрс байна.

I.4. Уурхайн техник, тоног төхөөрөмжийн хувьд.

Уурхайн уулын ажлыг Doosan экскаватор 2 ширхэг, хөрс тээврийн ажилд 25 тонн даацтай HOWA маркийн автосамосвал 3 ширхэг, хөрсний овоолго болон туслах ажилд D155A бульдозер 1 ширхэг, ZL50 маркийн утгуурт ачигч 1 ширхэг ашиглагдаж байна.

I.5. Хүний нөөц


Одоогийн байдлаар уурхайд 12 хүн ажиллаж байгаа бол төслийн хүрээнд орд ашиглалтын хугацаанд хамгийн ихдээ 30 хүн ажиллана. Уурхайн захиргаа, аж ахуйн албанд 17 хүн, ил уурхайд 8, засвар механикийн хэсэгт 5 хүн тус тус ажиллахаар тусгасан. Ажиллагчдын дундаж цалин 2158.2 мян.төг болно.

II. ТӨСЛИЙН ТАЛБАЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

II.1. Ордын байршил.

Чандган талын хүрэн нүүрсний орд нь Хэнтий аймгийн Мөрөн сумын нутагт орших ба байршлын хувьд Улаанбаатар хотоос 290 км, Хэнтий аймгийн төв Мөрөн сумаас баруун тийш 55 км зайд байрладаг. “Бэрх-Уул” ХК нь тус ордод MV-004590 тоот ашиглалтын тусгай зөвшөөр нийт 43.75 га талбайг эзэмшиж байна.

Зураг 1. Ордын байршил



Хүснэгт № 1. Тусгай зөвшөөрлийн талбайн газар зүйн дараах солбицлууд

MV – MV-004590						
Д/д	Уртраг			Өргөрөг		
	Град	мин	сек	Град	мин	сек
1	110	1	24.82	47	22	56.73
2	110	1	24.82	47	23	22.73
3	110	0	58.82	47	23	22.73
4	110	0	58.82	47	22	56.73

II.2. Бүс нутгийн физик газар зүйн мэдээлэл

Уул зүй: Тус орд газар нь Нялгын хотгорын зүүн хойд хэсэгт баруун урдаас зүүн хойш чиглэсэн Баянмөнхийн уудам хөндийд Шорвогийн тал хэмээх газар байрлах ба баруун хойгуураа Дашбалбарын уулсаар хүрээлэгддэг.

Түүний хамгийн өндөр цэгийн үнэмлэхүй өндөр 1579 м бөгөөд түүний харьцангуй өндөржилт 200-300 м-ээс үл хэтэрнэ. Зүүн хойд бэл нь баруун хойд бэлээсээ хэвгий. Дашбалбарын уулс нь эгц хад асга ихтэй, маш их хэрчигдсэн. Зүүн урдуураа 90-100 км орчим үргэлжилдэг Хонгорын уулсаар хүрээлэгдэх ба өргөн нь 7-30 км хүртэл үргэлжилнэ. Түүний хамгийн өндөр цэг бол Мөрөн сумын орчим, Улаан-Өндөр овоо юм. Үнэмлэхүй өндөр 1664 м. Хотгорын түшингээс дээш 450 м-т өргөгдсөн байна.

Ус зүй: Ордоос зүүн хойно 15 км зайд Мөрөн гол урсана. Мөн хэд хэдэн давст нууруудыг нэрлэж болно. Эдгээр нь зуны улиралд хатаж ширгэдэг байна. Мөрөн голын ус нь Хэрлэн голд хүрдэггүй, элювиаль хурдаст шингэж замхардаг. Хатсан голын голдирол,

ширгэсэн нуурын шал нь арзайж хатсан шавар бүрхэвчээр бүрхэгдсэн байдаг. Орд газар дээр Соль нэртэй давстай нуур байдаг ба талбайн хувьд бага, усаар заримдаа дүүрдэг бөгөөд идэгдлийн гаралтай битүү хэвгий хотгорт оршино. Мөрөн голын голдиrol нь уулархаг хэсэгтээ нарийн, огцом эрэгтэй, голын хөндий нэгээс хоёр дэнжтэй.

Уур амьсгал: Цаг уур, уур амьсгалын хувьд төслийн талбай нь Монголын ихэнх нутгийн адил эх газрын эрс тэс уур амьсгалтай, хүйтэн өвөл, харьцангуй сэрүүвтэр зунтай.

Өвлийн дундаж температур $-25-27^{\circ}\text{C}$ байдаг ба өвөлдөө хур тунадас 13-18 мм орчим унадаг. Хамгийн хүйтэн үе нь 01 сард тохиож $-30-38^{\circ}\text{C}$ хүрдэг, харин 2001 онд $-44,2^{\circ}\text{C}$ хүрч хүйтэрсэн байна. Цасан бүрхүүл 10 мм-ээс хэтэрдэггүй, хотгор газраа салхины нөлөөгөөр хунгарласан үед 1,0 м хүрнэ.

Хаврын улиралд нилээд салхилж 10-15 м/сек, цөөн тохиолдолд 25 м/сек хүртэл ширүүсдэг, шуурга 7 хоног үргэлжлэх нь үе үе тохиолдоно. Хавар салхины дундаж хурд 3,8-4,9 м/сек байна. Харин сүүлийн жил шуурганы эрч гамшигт байдалд хүрч, айл гэр, барилга байгууламжуудыг сүйтгэсэн тохиолдол олон гарлаа. Хур тундасны хэмжээ 20-30 мм хүрэх нь зөвхөн 5-р сард тохионо. 3-4 дүгээр сард ихэнхдээ хасах температуртай хааяа $+10+25^{\circ}\text{C}$ хүрнэ.

Зундаа салхилах нь багасч $+20+25^{\circ}\text{C}$ хүрч дулаарна. Хамгийн их халуун нь 7-р сард $+38^{\circ}\text{C}$ /2004 онд/ хүрнэ. Жилийн тунадасны 70-80% нь 7, 8-р сард унана. Зуны салхины дундаж хурд 3,0-3,6 м/сек орчим байдаг.

Амьтны аймаг: Орд газрын орчимд Монгол орны ургамлын аймгийн мужлалд үндэслэн гаргасан хөхтөн амьтадын газар зүйн тархалтын мужлалаар /Банников1954, Батсайхан 2006/ Дундад Халхын Хээрийн тойрогт хамаарагдах тул жинхэнэ тал хээрийн бүсийн амьтад энд тархсан байна.


II.3. Геологийн тогтоц

Чандган талын нүүрсний орд нь томоохон грабены төв хэсэгт брахиосинклиналь структурыг үүсгэн тогтдог. Энд доод цэрдийн Зүүнбаян формацын хурдас болон неоген, дөрөвдөгчийн хурдсууд тархсан байдаг.

Судлаачид Зүүнбаян формацын хурдсыг дотор нь дээд ногоон саарал, доод хар саарал гэж хоёр мэмбэрт ялгадаг. Үүний доод хар саарал зузаалаг нь манай талбайд байдаггүй. Харин дээд ногоон саарал зузаалаг нь өргөн тархалттай.

Доод ногоон саарал мэмбэр (K1dz2). Зүүнбаян формацын ногоон саарал мэмбэр нь ордын хэмжээнд хамгийн өргөн тархалттай хурдас юм. Энэ мэмбэр нь хурдсын литологийн найрлага шинж чанарын хувьд янз бүрийн ширхэгтэй сул цементлэгдсэн цайвар саарал өнгийн ногоовтор туяатай элсэн чулуу, ногоон саарал өнгийн аргиллит, шавар, алевролит, хүрэн нүүрс зэргээс бүрддэг. Энд янз бүрийн зузаантай нүүрсний 5 давхраас агуулагддаг. Гэвч тэдний нэгээс бусад нь үйлдвэрийн ач холбогдолтой байж чаддаггүй. Үйлдвэрийн ач холбогдол бүхий давхрагын зузаан нь дунджаар 34,5м байдаг. Бусад давхраасуудын зузаан нь 0,2-2м-т хэлбэлздэг. Ногоон саарал мэмбэрийг литологийн найрлагаас нь хамааруулж дээд, доод гэсэн хоёр зузаалагт ялгадаг.


Зураг 2. Геологийн зураг



II.4. Ордын тектоник

Чандганы нүүрсний орд нь тектоник хөдөлгөөн, тасрал эвдрэлд өртөөгүй маш энгийн тогтоцтой юм. Ордын агуулагч чулуулаг болон нүүрсний давхраасуудын суналын азимут нь хайгуулын I шугамаас баруун тийш орших хэсэгтээ ЗУ 95о-100о хайгуулын шугамаас зүүн тийш орших хэсэгтээ ЗУ 150о байдаг. Түүний уналын азимут нь БУ 5о-8о-аас хэтэрдэггүй. Ордын зүүн хойд хэсэгт взбросын төрлийн нэг хагарал байдаг. Түүний суналын азимут нь ЗУ 110о-115о, уналын азимут нь БУ 70о-75о байдаг. Шилжилтийн далайц нь хамгийн ихдээ 40о хүрдэг. Энэ хагарал нь нүүрсний II давхаргыг 2 хэсэгт хувиусан бөгөөд хагарал орчим эвдрэлийн бүс нь 5-7 м байгаа нь ашиглалтын явцад тохиолдсон байна.

Зураг 3. Нүүрсний давхрагуудын геологийн зүсэлт



II.5. Ордын геологийн тогтоц, нүүрсний чанар

1962 онд хийгдсэн нарийвчилсан хайгуулын ажлаар 120-150м зузаантай нүүрс агуулсан давхаргыг судалж үйлдвэрлэлийн ач холбогдолтойгоор 30.45-49.95м ашигтай зузаантай II давхаргыг тогтоосон байна.

Зураг 1. Нүүрсний давхрагуудын геологийн зүсэлт

Нүүрсний III, IV, V давхрагууд нь үндсэн II давхаргын уланд, I үе түүний таазанд оршдог.

Нүүрсний давхаргуудын товч тодорхойлолт:

Давхарга I нь хамгийн дээд хэсэгт орших ба 0.35м зузаантай, түүний таазанд аргиллит, уланд алевролит байна. Энэ нь талбайн баруун урд хэсэгт нэг л шурфээр илрүүлэгдсэн. Түүний талаарх геологийн мэдээлэл бүрэн бус тул итгэл үнэмшилтэй бүрэн тодорхойлолт өгөх боломжгүй.

Давхарга II нь нийлмэл бүтэцтэй ба өөр хоорондоо 0.1-6.0м хүртэл зузаантай хоосон чулуулгаар тусгаарлагдсан 3-4, түүнээс олон тооны багцаас бүрддэг. Дээрх давхаргын бүтэц хайгуулын шугамын I – I-ээс IV – IVшугамын чиглэлд нийлмэл шинжтэй болдог байна. Давхаргын тааз нь аргиллит, алевролит зэрэг шаварлаг чулуулаг зонхилдог бол түүний уланд сийрэг элсэн чулуу хаа сайгүй давамгайлдаг байна. 7101х талбайн тухайд 2007 оны өрөмдлөгөөр зөвхөн II давхрагыг судалсан. Тухайн талбайд II давхрага нь 28,85-48,85м-ийн зузаантай дунджаар 38,6м байна. II давхраас нь дундаа 10-27ш чулууны үеийг агуулдаг. Тэдний зузаан 0,02-0,78м байдаг ба тэдгээрийн ихэнх нь маш бага 0,02-0,06м-ийн зузаантай байдаг. II давхраас нь талбайн зүүн урд хэсэгт өөрөөр хэлбэл хайгуулын RH-07-01, RH-07-02 цооногуудад дундах чулууны үеүд нь зузаарч дөрвөн хэсэг болон салбарладаг.

Давхарга III нь II давхаргын дор 1.2-5.0м зайд орших ба 0.2-2.0м зузаантай. Ордын баруун хойд хэсэгт өргөн тархсан боловч зүүн урд хэсэгт түүний тархацын талаар өгөх мэдээлэл геологийн тайланд нотлогдоогүй бөгөөд дээрх давхарга нь тогтворжилтгүй ангилалд хамаарна.

Давхарга IV нь III давхаргын дор 20-23м оршино. Дээрх давхаргын таазанд аргиллит, алевролит, уланд алевролитын нимгэн үе, элсэн чулуу оршдог, тогтворжилтгүй ангилалд хамаарна.

Давхарга V нь IV давхаргын дор 3.85м зайд оршино. Давхаргын тааз ба уланд бага зузаантай алевролитын үе (хуурамч ул, тааз), үндсэн ул ба тааз нь элсэн чулуу юм. Давхаргын зузаан 0.15м байна.

II.6. Ордын нөөцийн тооцоо

Улсын төсвийн хөрөнгөөр Чандган талын нүүрсний орд газарт 1963 онд геологийн нарийвчилсан хайгуул хийж тус ордын нөөцийг A+B+C1 зэрэглэлээр 123,845.0 мян.тн (A-13,036.0 мян.тн, B-37,632.0 мян.тн, C1-72,177.0 мян.тн), C2 зэрэглэлээр 90,139.0 мян.тн гэж тус тус тооцож, улсын нөөцөд бүртгүүлсэн байна.

Өнөөгийн байдлаар тус орд дээр “Бэрх-Уул” ХК, “Чандганкоул” ХХК, “Тефис Майнинг” ХХК гэсэн 3-н компани ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа болно.


Дээрх компаниудын эзэмшиж буй хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай бүрт оногдох Цайдам нуурын нүүрсний ордыг 3-н талт хэлэлцээр хийж АМГ-ын мэргэжилтнүүдийн зөвлөснөөр баталгаажуулсан байна.

А, В, С1 зэргээр нийт 21278.9 тн нүүрсний нөөц тооцоолсон байна. 2011 онд батлагдсан дээрх нөөцийг одоог хүртэл олборлож байна.

Хүснэгт 2. Нүүрсний үлдэгдэл нөөц

Нөөцийн зэрэг	Нийт нөөц, тн
А	3030.73
В	11927.48
С1	5585.47
А+В+С1	20,490.82

Зураг 4. Нүүрсний давхаргын 3D зураг



БҮЛЭГ-III. ИЛ УУРХАЙН ТӨЛӨВЛӨЛТ


III.1. Уурхайн өнөөгийн байдал

Тус нүүрсний орд газарт жилд 30 мянган тонн нүүрс олборлох хүчин чадалтай ил уурхайн төслийг 1960 онд ТЭХХҮЯ-ны харьяа ЗТЭШИ-ээс боловсруулж 1967 оны 6-р сарын 1-нд ил уурхай байгуулагдаж ашиглалтанд оржээ. Төслийн талбайд 100 мян.тн нүүрс олборлох зураг төслийн ажлууд ашиглалтын явцад шат дараалалтайгаар хийгдэж байсан (1981он) бөгөөд оргил үедээ 123.8 мян.тн нүүрс гаргалтын ажлыг хийж (1991он) бүс нутгийн хэрэгцээг бүрэн хангасан томоохон уурхай байсан. Одоогийн байдлаар уурхай жилдээ 30 мян.тн нүүрсийг жил бүр гарган хэрэглэгчдэдээ нийлүүлж байна.


Зураг 5. Ил уурхайн одоогийн байдал




Зураг 2. Ил уурхайн өнөөгийн байдлын 3D зураг



Ил уурхайн өнөөгийн байдлын 3D зураг



Зураг 7. Нүүрсний биетийн 3 хэмжээст зураг



III.2. Уулын ажил


Уурхайн ашиглалт явуулах дарааллыг уурхайн хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажлын календарчилсан төлөвлөгөө, компанийн техникийн даалгаврын хүрээнд өгөгдсөн жилийн хүчин чадал, уурхайн хүрээн дэх хөрсний эзлэхүүн, түвшин бүрээр тооцсон нүүрсний үйлдвэрлэлийн нөөц зэргийг үндэс болгов. Уурхайн ашиглалт явуулах дараалал нь бүтээгдэхүүн гаргалтын төлөвлөлтийн зорилгод нийцнэ. Уурхайн ашиглалт явуулах дараалал доорх алхмуудын дагуу гүйцэтгэсэн.

Үүнд:

- ✓ Хөрс хуулалтын хэмжээ жигд байх;
- ✓ Нүүрсний борлуулалтын зах зээлийн зорилтуудыг хангах;
- ✓ Уурхайн ухаж ачих тоног төхөөрөмжийн жилийн цаг ашиглалтын хэмжээ болон бүтээлийг хамгийн их байлгах;


Төлөвлөлтийн үр дүн нь тоног төхөөрөмжийн шаардлагатай тоо хэмжээг тодорхойлох болон эдийн засгийн модель үүсгэхэд ашиглах

Зураг 8. Ил уурхайн уулын ажлын ахилт, (Зүсэлт А-А')



Ил уурхайн 2024 оны эцсийн байдлаар 30.7 мян.тн нүүрс олборлож, 47,9 мян.м³ хөрс хуулалт хийсэн байна. Хөрс хуулалтын дундаж коэффициент 4.52 м³/тн байна.

Зураг 9. Ил уурхайн эхний жилийн эцсийн байдлын 3 хэмжээст зураг



III.3. Ил уурхайн механикжуулалт үндсэн тоног төхөөрөмж

Ил уурхайн олборлолтод ажиллах тоног төхөөрөмжүүдийг дараах хүснэгтээр үзүүллээ.


Хүснэгт 3. Ил уурхайд ажиллах үндсэн болон туслах тоног төхөөрөмжүүд

Д/д	Тоног төхөөрөмж	Марк	Үзүүлэлт	Нэгж	Утга	Ажлын зориулалт
1	Экскаватор	Doosan-300	Утгуурын багтаамж	м³	1.2	Нүүрс
2	Экскаватор	Doosan-500	Утгуурын багтаамж	м³	2.9	Хөрс
3	Автосамосвал	Howo	Даац	тн	25	Хөрс тээвэр
4	Автосамосвал	Howo	Даац	тн	25	Хөрс тээвэр
5	Утгуурт ачигч	ZL50	Утгуурын багтаамж	м³	3.5	Нүүрс ачилт, бусад ажил
6	Бульдозер	D155A	Хусуурын хамах чадвар	м³	3,5	Туслах ажил

III.4. Ил уурхайн ажиллах горим

Уурхайн эхний жилд хөрс хуулалтын ажлыг 8-р сараас 10-р сарын 15 хүртэл, нүүрс олборлолтын ажлыг 10-р сарын дунд үеэс дараа оны 4-р сарыг дуустал үргэлжилнэ. Уурхайн хөрс хуулалтыг гадаад овоолго үүсгэн хуулалт хийнэ. Уулын ажил нь цаг агаарын саатал, төлөвлөгдөөгүй техникийн засвар үйлчилгээ, сул зогсолтоос хамааран эхний жилд баяр ёслол, амралтын өдрүүд 15 хоног, цаг агаараас хамаарсан сул зогсолт 10, уурхайн жилд ажиллах бодит хоног 300 хоног байна.

Зураг 10. Ил уурхайн ажлын горим




Хүснэгт 4. Уурхайн ажлын горим

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Утга
1	Календарийн хоног	хоног	365
2	Баяр ёслол, амралтын өдрүүд	хоног	15
3	Цаг агаараас хамаарсан сул зогсолт	хоног	10
4	Төлөвлөгөөт сул зогсолт	хоног	40
5	Уурхайн жилд ажиллах бодит хоног	хоног	300
6	Хоногт ажиллах ээлжийн тоо	-	1
7	Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12
8	Ээлжийн сул зогсолт (цайны цаг)	цаг	1
9	Ээлжийн сул зогсолт (ээлж солилт, түлш тос, солилт)	цаг	1
10	Ээлжийн цаг ашиглалтын коэффициент	-	0.83
11	Уурхайн хоногт ажиллах бодит цаг	цаг	10
12	Уурхайн жилд ажиллах бодит цаг	цаг	3000

III.5. Шимт хөрсний овоолгын ажил

Хуулалтад хамрагдах үржил шимт болон потенциал үржил шимт хөрсний үе давхаргын зузааныг төслийн талбайд хийсэн хөрсөн бүрхэвчийн үржил шимт байдлын түвшний үнэлгээ, үндсэн хэв шинж ба дэд хэв шинжүүдийн хөрсний зүсэлтийн бие даасан генетик горизонтуудын хаяалбаруудын тус тусын үржил шимт байдлын үнэлгээ дээр үндэслэн үржил шимт хөрсийг 20 см-ээр MNS 5916:2008 стандарт шаардлагын дагуу Бульдозероор хуулж хадгална.


Зураг 11. Шимт хөрсийг бульдозероор хуулах технологийн бүдүүвч



III.6. Хөрсний овоолгын ажил

Ордыг ашиглах үед хөрс хуулалтыг гадаад овоолгод автосамосвалаар тээвэрлэн бульдозерын тусламжтай овоолго үүсгэв. 2024 онд нийт 47,9 мян.м³ хөрс хуулсан байна. Хөрсний гадаад овоолгыг өмнөх жилүүдэд үүссэн овоолгод хураав. Гадаад овоолгын нийт эзлэхүүн 746.58 мян.м³ +1170 м - +1181 м хүртэл 11 м байна. Гадаад овоолгын хажуугийн өнцөг 30.69°. Гадаад овоолго байршсан талбайн хэмжээ 4.31 га.


Зураг 12. Хөрсний гадаад овоолго



III.7. Уурхайн үйл ажиллагааны явцад эвдрэлд өртсөн талбайн хэмжээ.

Ил уурхайн ашиглалтын төлөвлөгөөгөөр хөрсний гадаад овоолго, үржил шимт хөрсний овоолго, уурхайн хотхон, баяжуулахын талбай, авто зам зэрэг нь өмнөх жилүүдэд үүссэн овоолго болон зам талбайг ашиглав. 2023 онд ил уурхайн ашиглалтаар 0.73 га талбай хөрс хуулалтад өртсөн байна.


Зураг 13. Уурхайн ашиглалтын карьер.



III.8. Техникийн нөхөн сэргээлт

Чандган тал уурхайн нөөцийг бүрэн олборлож дуусаагүй бөгөөд нүүрсний давхаргыг бүрэн олборлож дуустал техникийн нөхөн сэргээлтийг уурхайн ашиглалтын карьерт хийхгүй. Ил уурхайн одоогийн хөрс хуулалтын түвшин +1148-р түвшинд 20м байгаа бөгөөд уурхайн эцсийн хүрээ +1110 түвшин хүртэл уурхайн гүнзгийрэл 38м хүрэх юм.

Зураг 14. Ил уурхайн ашиглалтын хүрээ



III.9. Биологийн нөхөн сэргээлт

2024 онд биологийн нөөхөн сэргээлтийг хийхгүй бөгөөд ил уурхайн үйлдвэрлэлийн нөөцийг бүрэн олборлож, овоолгын болон талбайн хөрс чулуулаг тогтворжиж, нягтарсны дараа овоолгод хадгалж байсан шимт хөрсөөр хучилт хийж эвдэрсэн газарт биологийн нөхөн сэргээлтийн ажлыг эхлүүлнэ.

Биологийн нөхөн сэргээлтийн ажлыг олборлолтын ажил эхлэхийн өмнө уурхайн эдэлбэрийн байгаль орчны суурь нөхцөл байдлыг тодорхойлох урьдчилсан судалгаа явуулах, дараа нь уг судалгааны үр дүн болон бусад мэдээ, мэдээлэлд үндэслэн ургамалжуулах ажлын чиглэлийг тогтоох, эцэст нь техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайд шимт хөрсний үе үүсгэн ургамалжуулалтыг байгалийн аясаар болон зохиомлоор тарьж ургуулах гэсэн дэс дараалалтайгаар гүйцэтгэнэ.

IV. ХОГ ХАЯГДАЛ

Хатуу, шингэн хог хаягдал нь хүн ам, үйлдвэрлэлд хэрэгцээт газрын нөөцийг багасгах, хөрс, ус, агаарыг хорт бодис, хүнд металл, нян вирусээр бохирдуулагч гол эх үүсвэр болдог. Хатуу хог хаягдал нь удаан задарч бодисын эргэлтэд аажмаар орох ба задрах хугацаа нь удаан байдаг учраас байгаль орчинд хор хөнөөлтэй.

“Бэрх-уул” ХК-ний “Чандган тал” хүрэн нүүрс олборлох төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд ноцтой хохирол учруулахуйц хатуу, шингэн хог хаягдал гарахгүй. Төсөл хэрэгжих явцад гарах хог хаягдлыг гарал үүслээр нь:

А. Ахуйн хог хаягдал

Б. Технологийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдал

Төслийн үйл ажиллагааны явцад гарах хог хаягдал нь ахуйн болон технологийн үйл ажиллагаанаас үүснэ. Хэлбэрээр нь:

1. Хатуу
2. Шингэн
3. Хийн гэж ангилна.

Төсөл хэрэгжих хугацаанд дараах зарчмыг дагаж мөрдөж ажиллана.

Зураг № 15. Уурхайн хог хаягдлын менежмент



Эдэлгээг сайжруулах буюу Сэргийлэх – гүйцэтгэгч байгууллагууд аливаа нөөцийг ариг гамтай зохицуулах, ашиглах замаар хог хаягдал бага гаргах. Үүний тулд худалдан авалт, хангамжийн сайн туршлага болох сав, баглаа боодол багасгах, цэгцтэй байлгах зэргийг хангах /Төслийн хэрэгжих явцад ашиглах бүх нөөцийг ариг гамтай ашиглаж, эдэлгээг уртасгана./

Эрс багасгах–Төсөл хэрэгжүүлэгч аливаа нөөцийг ариг гамтай зохицуулах, ашиглах замаар хог хаягдал эрс багасгах арга хэмжээг урьдчилан авах

Эргүүлж ашиглах – цэвэр шороог нүх булах зэргээр хог хаягдлыг талбай дээр байгальд халгүй байдлаар дахин ашиглах. Дахин ашиглах зарим хаягдлыг зохих газруудад худалдаж эсвэл үнэгүй нийлүүлэх. /Төслийн хэрэгжих явцад гарсан шороо байгальд халгүй эргүүлж ашиглах/

Эргүүлж боловсруулах – эргүүлж боловсруулах хаягдлыг цуглуулж, зохих газруудад худалдаж эсвэл үнэгүй нийлүүлэх. /Төслөөс гарах эргүүлж боловсруулах боломжтой бүх хаягдлууд хамаарна. Жишээ нь: ажилласан тос тосолгооны материал, хуванцар сав, гялгар уут, элдэв төмрийн хог хаягдал, хайрцаг сав баглаа боодол/

Эцэслэн хаях - эргүүлж ашиглах болон боловсруулах боломжгүй хаягдлыг хотын төвлөрсөн хогийн цэг рүү ТҮГ-аар тээвэрлүүлэн зайлуулах /Төслөөс эцэст нь гарах бүх хог хаягдлууд хамаарна/.

V. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Зорилго, зорилт: Чандган тал уурхайн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний нэмэлт тодотгол тайлангаар тодорхойлогдсон төсөл хэрэгжүүлэгчийн хүлээх үүрэг амлалтаас гадна

Монгол Улсын Байгаль орчны багц хууль, холбогдох дүрэм журам, стандартуудын шаардлагуудыг мөрдлөг болгон боловсруулсан бөгөөд энэ төлөвлөгөөнд тусгагдсан үүрэг даалгавруудыг биелүүлэхийг гол зорилго болгосон.

Хамрах хүрээ: Чандган тал уурхайн MV-04590 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд хүрэн нүүрсний ордыг ил аргаар ашиглах төсөл.

V.1. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Чандган тал хүрэн нүүрс олборлох төслийн БОНБНҮ-ээр төслийн гол болон болзошгүй нөлөөллийг дараах байдлаар тодорхойлсон байдаг.

Чандган тал хүрэн нүүрс олборлох төслийн БОНБНҮ-ээр төслийн гол болон болзошгүй нөлөөллийг дараах байдлаар тодорхойлсон байдаг.

V.2. Агаарын чанарт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

БОННҮ болон компанийн дотоод бичиг баримт болох агаар мандалд ялгарах бохирдлын удирдлагын төлөвлөгөөнд агаарын чанарт нөлөөлөх үйл ажиллагаануудыг тодорхойлсон байдаг. Тухайлбал: хүнд машин механизм, бүх төрлийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, хөрсний овоолгууд ил уурхай зэргээс агаарын чанарт нөлөөлөх сөрөг нөлөөллүүд бий болох эрсдэлтэй.

Эдгээр эх үүсвэрүүдээс хүрээлэн буй орчны агаарын чанарт нөлөөлж буй аливаа сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

-  Тээврийн хэрэгсэл, хүнд машин механизмын хөдөлгөөнөөс тоосжилт бий болох
-  Баяжуулах орчмын талбайгаас тоосжилт бий болох
-  Хүнд машин механизм засварын газар, машины зогсоол дахь машин, техникүүд агаар орчныг бохирдуулах
-  Хөрс болон элс тээвэрлэлтээс үүссэн тоосжилт, агаарын бохирдол үүсэх

V.3. Усны нөөц, чанарт гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга

“Бэрх уул” ХК-ийн усны менежментийн бодлогын хүрээнд уурхайн бүх үйл ажиллагаанд усыг зөв зохистой хэмнэлттэй хэрэглэх, мөн үйл ажиллагаа явуулж буй бүс нутгийн усны нөөц, чанарт учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, орон нутгийн иргэдийн хэрэглээний усны нөөц, чанарыг хэвээр хадгалахыг зорин ажиллана.

БОННҮ-ийн дагуу усны нөөц, чанарт учирч болзошгүй дараах сөрөг нөлөөллүүдийг тодорхойлоод байна. Үүнд:

-  Усны менежментийн төлөвлөлтийг зөв оновчтой гаргаагүйгээс уурхай үйл ажиллагаанд хэмнэлт, дахин ашиглахгүй ашигласнаар усны нөөц хомсдох, нөөцөд хохирол учрах
-  Эргэлтийн усан санд усан толионоос ууршилт бий болж, усны алдагдал үүсэх
-  Газрын доорх усыг ашигласнаар усны нөөц хомсдох, нөөцөд хохирол учирч болзошгүй
-  Тунаах далан, эргэлтийн усан сангийн уснаас нэвчилт үүсэх болон далан сэтрэх зэрэг ослоос процессын ус алдагдаж, хөрсөөр дамжин газрын доорх усыг бохирдуулж болзошгүй

V.4. Газрын хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл

Чандган тал уурхайн үйл ажиллагаагаар газрын гадаргад овоолго үүсэж гадаргын хэлбэр дүрс өөрчлөгдөх, зам, байгууламж баригдаж газрын гадарга эвдэгдэх, ил уурхайн ашигт малтмал олборлолтын үйл ажиллагаагаар газрын гадарга, хэвлий ухагдаж хоосон орон зай (ухмал) бий болох, газрын гадаргын суулт үүсэх, тул газрын гадарга, хэвлийн

эвдрэлийг аль болох бага хэмжээнд байлгах шаардлагатай. ШТМ-ын агуулах, ШТС, ШТМ алдагдсанаар газрын гадарга, хэвлийг бохирдуулах сөрөг нөлөөллүүд үүснэ.

V.5. Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл

Уурхайн үйл ажиллагаа, олборлолт, ашигт малтмал ашиглах, автозам байгуулах, ашиглах үед үүсэх дараах сөрөг нөлөөллүүдийг тодорхойлоод байна. Үүнд:

 Газар ашиглалтын үед хөрсөн бүрхэвч алдагдах

 Хуулсан шимт хөрсийг зүй зохистой хадгалаагаагүйгээс салхинд хийсэн, үржил шим алдагдах.

V.6. Ургамлын аймаг, ургамлын нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл

Уурхайн үйл ажиллагаа, тээврийн хөдөлгөөн, зөвшөөрөлгүй шороон зам ашигласнаас ургамлын нөмрөг нөлөөлөлд өртөж доройтох, дарагдах, устах эрсдэлүүдийг тооцсон байна.

V.7. Амьтны аймагт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээгээр уурхайн үйл ажиллагааны улмаас амьтны аймагт үзүүлж болзошгүй дараах нөлөөллийг тодорхойлж, бууруулах арга хэмжээг төлөвлөсөн. Үүнд:

 Амьдрах орчны шууд хомсдол

 Уурхайн үйл ажиллагаанаас үргэж дайжихаас үүдсэн зэрлэг амьтдын амьдрах орчны шууд бус хомсдол

 Идэш тэжээлийн хэлхээнд өөрчлөлт орох буюу махчин амьтны тоо өсөхөөс шалтгаалсан шууд бус үхэл хорогдол

VI. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Чандган талын нүүрсний уурхайн ашиглалтын одоогийн байдал болон ашиглалт явуулах хил хязгаар, ашиглах тоног төхөөрөмж зэргийг тооцон үзэхэд амьтны аймаг, ургамлын бүрхэвч, бэлчээрт үзүүлэх онцгой хортой нөлөөлөл байхгүй.

Уурхайн орчимд гадаргын усан сүлжээ байхгүй бөгөөд уурхайн талбайгаас зүүн урдуур

22 км зайд Мөрөн гол урсдаг. Иймээс уурхайн ашиглалт олборлолтын үйл ажиллагаанаас бохирдож устаж алга болох гэх мэтээр гадаргын усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл байхгүй болно.

Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор: Чандганы нүүрсний уурхайн тоосжилт болон бохирдуулагч хийн нөлөөгөөр орчны агаар бохирдох, ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхөөс сэргийлж агаар дахь SO₂, NO₂, тоосжилтыг тодорхойлуулах, хяналт шинжилгээ хийлгэх, тээвэрлэлт хийх автомашинуудын хурдны хязгаарлалтын тэмдэг, тэмдэглэгээг засаж сайжруулан байршуулах, ажилчдын болон оффиссын барилгын уурын зуухны янданд шүүлтүүр тавих, ажлуудыг гүйцэтгээд байна. Мөн уурхайн карьер болон шимт хөрсний овоолго, ажилчдын байр зэрэг өмнө хийж байсан тогтсон 3 цэгт хэмжилт хийлгэн аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн байгаль орчны лабораторид шинжилгээ хийлгэсэн. Шинжилгээний үр дүн болон дүгнэлтийг тайланд хавсаргав.

Тээвэрлэлт хийх машины хурдыг хязгаарлаж, хурдны хязгаарлалтын тэмдэг тэмдэглэгээг сайжруулан, байршуулсан.

Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд: Бохир усыг стандартын шаардлага хангасан битүүмжлэл сайтай, ус нэвтрэхгүй төмөр бетон доторлогоотой тусгай бохирын цооногт хуримтдлуулдаг. Тиймээс бохирын цооногын тэмдэг, тэмдэглэгээг сайжруулсан. Мөн ажилдын ундны ус болон уурхай доторх худаг, шүүрлийн ус зэрэгээс 3 сорьц авч аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн байгаль орчны лабораторид шинжилгээ хийлгэсэн. Шинжилгээний үр дүн болон дүгнэлтийг тайланд хавсаргав.

Хөрсөн бүрхэвч, гадаргын хэлбэрт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд: Нефтийн бүтээгдэхүүн асгарч, орчны хөрс бохирдуулахаас сэргийлж ШТМатериалыг стандартын шаардлага хангасан саванд хадгалах, асгарч алдахаас сэргийлэн ажилласан. Мөн засварын талбай болон засвар хийгдсэн бусад газруудад хэрэглэсэн тос, цэвэрлэх материалыг хийх тусгай савнуудыг шинэчлэн засаж, байрлуулсан.

Хөрс элэгдэл, эвдрэлд орох, үржил шимээ алдах, чийг буурах, бохирдох, гадаргын болон унаган хэлбэр өөрчлөгдөхөөс сэргийлж уурхайн эдэлбэр газарт олон салаа зам гаргахгүй, замын сүлжээг цэгцтэй болгож үйлдвэрийн технологийн замуудын эхэнд анхааруулах тэмдэг тэмдэглэгээг тавих, уурхайд ажиллах машинууд болон бусад техникүүдэд шатахуунаар цэнэглэх талбай болон зориулалтын талбай зассан. Нефьт ачиж, буулгах цэг болон шимт хөрсний овоолго, уурхайн нөлөөллийн бүс зэргээс 2 сорьц авч аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн байгаль

орчны лабораторид шинжилгээ хийлгэсэн. Шинжилгээний үр дүн болон дүгнэлтийг тайланд хавсаргав.

Ургамлан нөмрөг хамгаалах, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр: Уурхайн бүсээс 1 ургамлын дээж авч аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн байгаль орчны лабораторид шинжилгээ хийлгэсэн. Шинжилгээний үр дүн болон дүгнэлтийг тайланд хавсаргав.

Ажилчдын байрны гадна талбайд ногоон байгууламж бий болгох зорилгоор өмнөх онуудад суулгасан улиасны тарьцнаас муу ургалттай моднуудыг шинэчлэн сольж, ургалт өсөлтөд нь анхааран хамгаалах торон хашаа барьж ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд 2024 онд 1000 ш улиас, 1000 ширхэг хармаг нийт 1 орчим га-д суулгаж арчлан амжилттай ургуулж байна. Хармаг суулгац худалдан авахад 10 сая төгрөг зарцуулсан. Мөн чихэр өвс, хунчир, дэрэвгэр жиргэрүү зэрэг 3-н төрлийн ургамлыг нутагшуулах зорилготой үрээр тарьж туршиж үзэж байгаа юм. Үүнийг худалдан авахад 0.86 сая төгрөг зарцуулсан. Эдгээр 3-н төрлийн ургамлын үрийг нийт 0.2 орчим га-д суулгасан. Биологийн нөхөн сэргээлт хийгдэж буй талбайг хамгаалан торон хашааг үргэлжлүүлэн барьж засварлан ажиллаж байна.

VI.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Хүрээлэн буй орчны агаарын чанарын нөлөөлж буй аливаа сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэв.

Хүснэгт 5. Агаарын чанарын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	2024 оны БОМТөлөвлөгөө			2024 оны БОМТөлөвлөгөөний биелэлт	
	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулахаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	
1.	Ил уурхайн олборлолт болон хүнд машин механизмын хөдөлгөөнөөс тоосжилт бий болох	Замын тоосжилтыг бууруулах зорилгоор усалгаа хийх	Уурхайн талбайн дотоод болон гадаад зам, кемп хүртэлх зэрэг бүх зам.	Ил уурхайн технологийн зам болон уурхайн хотхоны чиглэлийн замуудад салхи ихтэй хуурайшилттай өдөр усалгааг хийж байна.	
2.	Тоосжилт болон бохирдуулагч хийн нөлөөгөөр орчны агаар бохирдох	Ажлын байрны агаарын чанарыг сайжруулах, тоосжилтыг бууруулах арга хэмжээ тогтмол авч усалгаа хийж байх;	Уурхайн хотхон	Уурхайн талбай нь бусад бүс нутгуудтай харьцуулахад хур тунадас харьцангуй их, хуурайшилт бага байхаас гадна, салхины хурд өндөр байдаг. Ил уурхайн үйл ажиллагааг хуурайшилт ихтэй болон, салхины хурд өндөр өдөр тор зогсоож тоосжилт үүсэх суурь нөхцөлтэйгөөс сэргийлсэн.	
3.		Уурхайн ухалт, ачилт буулгалтын цагийг хоногийн салхины горимтой уялдуулан зохион байгуулах	Ашиглалтын карьер болон гадаад овоолгын талбай		
4.		Хүнд механизмын хөдөлгүүрийн тохиргоо, үйлчилгээг тогтмолжуулах, хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах арга хэмжээ авах;	Ашиглалтын болон хөрс, элс тээвэрлэлтийн машин механизм		
5.	Агаарын бохирдлын улмаас уурхай дахь ажлын нөхцөл, ажилчид болон нутгийн иргэдийн эрүүл мэндэд нөлөөлөх	Уурхайн карьер доторх болон түүнээс гарч буй замыг засаж байх	Уурхайн талбайн дотоод болон гадаад зам, кемп хүртэлх зэрэг бүх зам.	Уурхайн карьер болон гадаргуугийн замын арчилгаа, засвар үйлчилгээг бульдозероор засаж сайжруулдаг.	
6.		Тоосноос эрүүл мэндээ хамгаалах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах.	Нийт ажилчид		

VI.2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 6. Усны нөөцөд учруулж болзошгүй сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

№	2024 оны БОМТөлөвлөгөө			2024 оны БОМТөлөвлөгөөний биелэлт
	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулахаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
1.	Усны менежментийн төлөвлөлтийг зөв оновчтой гаргаагүйгээс уурхай үйл ажиллагаанд усыг урт хугацаанд хэмнэлт, дахин ашиглалтгүй ашигласнаар усны нөөц хомсдох, нөөцөд хохирол учрах	Байгаль орчныг хамгаалах, цэвэр усны нөөцийг хэмнэх зорилгоор уурхайн унд ахуйн усыг хэмнэлттэй ашиглах.	Элс угаан баяжуулах технологийн хэсэг	Чандган тал уурхайн нийт ажилчдад “SAVE WATER ” сэдэвт сургалт хийсэн. Сургалт дараах сэдвийг хамрав: ✓ Уурхайн усны хэрэглээ ✓ Бид яагаад усыг хэмнэх ёстой вэ? ✓ Усыг зохистой хэрэглээгүйгээс усны алдагдал их хэмжээтэй гардаг. Усыг алдагдалгүй, хэмнэлттэй, дахин ашиглах гурван зарчмын тухай Уурхайн өглөөний зааварчилгаа дээр “Усыг хэмнэх, Усны үнэ цэний” талаар онцолж бүх ажилчдад талцуулдаг. Уурхайн эргэлтийн усан сан нь ил уурхайн ашиглалтаар үүссэн карьерын шүүрлийн ус бөгөөд эргээсээ халих эрсдэл маш бага. Шүүрлийн нуурыг заагласан даланг хөрсний дотоод овоогоор дүүргэлт хийж далан тавьсан.
2.		Усны зохистой ашиглалтын талаар сургалт явуулах	Үндсэн болон гэрээт компанийн шинэ ажилчид, болон зочид	
3.	Эргэлийн сангийн уснаас нэвчилт үүсэх болон далан сэтрэх зэрэг ослоос процессын ус алдагдаж, хөрсөөр дамжин газрын доорх усыг бохирдуулж болзошгүй	Шүүрлийн нуур болон тунаах нуурын далангийн, хяналт шинжилгээг тогтмол хийх	Эргэлтийн сан, Тунаах нуур	

VI.3. Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ төлөвлөгөө

Хүснэгт 7. Газрын хэвлий, хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд

№	2024 оны БОМТөлөвлөгөө			2024 оны БОМТөлөвлөгөөний биелэлт	
	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулахаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	
1	Газрын гадарга, хэвлий эвдэгдэх, доройтох, нөлөөлөлд өртөх	Хяналтгүйгээр газар хөндөхөөс сэргийлж аливаа газар хөндөх үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө Газар хөндөх зөвшөөрөл авах, олгох, Газарзүйн мэдээллийн систем (ГМС)-д бүртгэл хөтлөх	Ил уурхайн ашиглалтын талбай	Ил уурхайн үйл ашиглалтын явцад уурхайн олборлолтын нөлөөлөлд өртөх газрын эвдрэлийг хамгийн бага хэмжээнд хязгаарлах, хяналт, бүртгэлийн системийг хэрэгжүүлэхийн тулд уулын мастерын зөвшөөрөлгүй газар хөрс хууддаггүй бөгөөд 2024 онд 0,73 га талбай ил уурхайн ашиглалтад өртсөн байна.	Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал MNS 5915 : 2008

VI.4. Ургамлын аймаг, ургамлын нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 8. Ургамлын аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

	2024 оны БОМТөлөвлөгөө			2024 оны БОМТөлөвлөгөөний биелэлт	
	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулахаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	
1.	Ургамлын нөмрөг устаж, дарагдах, нөлөөлөлд өртөж доройтох	Ургамлын бүрхэвч, ховор ургамлын судалгааг талбай хэмжээнд хийж, ховор, нэн ховор ховор ургамлын тархалтын мэдээллийг бүртгэж, зураглал гаргах.	Ил уурхайн ашиглалтын талбай	БОНҮТ-н ургамлын бичиглэлээр уурхайн тусгай зөвшөөрлийн талбайд нийт 18 овог, 47 төрөл, 67 зүйл ургаж байгаагаас 26 зүйл бэлчээрийн (38.81%), 26 зүйл эмийн ашигт ургамал (38.81%), 21 зүйл хөл газрын ургамал (31.34%) бүртгэгдэж байна. Тус талбай дотор 11 зүйл нэг наст өвслөг ургамал (16.42%), 52 зүйл олон наст өвслөг ургамал (77.61%), 4 зүйл сөөг, заримдаг сөөгөнцөр ургамал (5.97%) ургаж байгаагийн дотор нэн ховор, ховор, унаган, үлдвэр ургамлын	

	Ил уурхайн гадаад овоолго болон замын төлөвлөлтийг хийдээ ховор, нэн ховор ховор ургамлыг нөлөөнд өртүүлэлгүй төлөвлөх.	Ил уурхайн ашиглалтын талбай	бүртгэлийг гаргахад нэн ховор ургамал Монгол алтанхундага (Adonis mongolica Simonovicz.), ховор ургамал бүртгэгдээгүй, Монголын унаган ургамал Цагаан хунчир (Astragalus galactites Pall.) 1 зүйл, Монголд байгаа завсарын унаган ургамал Жижиг навчит харгана (Caraganamicrophylla (Pall) Lam.) бүртгэгдсэн.
--	---	------------------------------	---

VI.5. Амьтны аймагт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө


Хүснэгт 9. Амьтны аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	2024 оны БОМТөлөвлөгөө			2024 оны БОМТөлөвлөгөөний биелэлт	
	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулахаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	
1.	Дуу чимээ, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, гэрлийн нөлөөгөөр байршиж буй газар нутгаасаа үргэх, дайжих; амьдрах орчны шууд хомсдол, хуваагдалд орох	Тээвэрлэлт хийх үед ховор амьтадын дуу чимээ, гэрлийн нөлөөгөөр үргээж дайжуулахгүй байх.	Хөрс, элс тээвэрлэлтэд ашиглагдаж буй замууд	Төслийн үйл ажиллагаанаас үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах үүднээс тухайн амьд организмын амьдрах бичил орчныг бүрдүүлэх хэрэгтэй. Үүний тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэв. Үүнд: - Хууль бус агнуур хийх, амьтны үр зулзага, үүр өндгийг сүйтгэх зэрэг зөрчлийг гаргуулахгүй байхад онцгой анхаарч, энэ талаар ажилчдад зааварчилгаа өгөв. - Төрөл бүрийн техник хэрэгслийг зөвхөн тогтоосон маршрутаар явуулж байв. - Автомашинаас гарах утааг стандарт түвшнээс хэтрүүлэхгүй. - Жолооч, ажилчдын дунд байгаль хамгаалах талаар сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах - Ажлын шаардлагаар ухсан нүх, цооногт хүн, мал, зэрлэг ан амьтан орохоос сэргийлсэн хамгаалалтын түр хашаатай байлгах, ашиглалтын дараа ухсан нүх цооногийг анхны төлөв байдалд дүйцүүлэн нөхөн дүүргэх (250-аас ихгүй хэвгийтэй)	Амьтны тухай хууль - Байгаль орчныг хамгаалах тухай хууль - Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ
2.	Амьтад тээврийн хэрэгсэлд дайруулах, хууль бус агнуур гэх мэтээр үхэж, хорогдох эрсдэлтэй	Хууль бусаар амьтан агнах, ургамал түүх, тэдгээрийн гаралтай түүхий эдийг тээвэрлэх, ашиглахыг хориглох тухай компанийн дотоод журмын хэрэгжилтийг хангах үүднээс үзлэг шалгалт хийх болон ажилчдад сургалт явуулах, мөн мэдээлэл өгөх	Хөрс, элс тээвэрлэлтэд ашиглагдаж буй замууд		

IV. Биологийн нөхөн сэргээлт-мод тарилт

Монгол Улсын ойн сан бүхий газар 2018 оны байдлаар 18.5 сая. Га буюу нийт нутаг дэвсгэрийн 11.8%-ийг эзэлж, үүнээс 12.3 сая.га нь ойгоор бүрхэгдсэн (хэвийн ургаж байгаа), 5.6 сая.га нь ойгоор бүрхэгдээгүй (түймэр, мод бэлтгэл, хөнөөлт шавжид нэрвэгдсэний улмаас доройтолд орсон ой), 543.4 мян.га нь ойн сан доторх ойн бус талбай байна. Ойн сан бүхий газрын ойгоор бүрхэгдсэн талбайг нийт газар нутагт харьцуулсан хувь буюу ойрхог чанар 7.9 % байна (Монгол орны байгаль, орчны төлөв байдлын тайлан 2018 он). 2018 оны байдлаар ойн сангийн 1836.5 мян.га талбай ойн түймэр болон хөнөөлт шавжид, 0.9 мян.га талбай байгалийн гамшигт (салхи, шуурга, цас) нэрвэгдсэний, 106.7 мян.га талбай мод бэлтгэл явагдсаны улмаас доройтолд орсон байна (Монгол орны ойн сан. 2018. УБ. Ойн судалгаа хөгжлийн төв). Доройтсон ойн талбайг нөхөн сэргээх, ойжуулах замаар ойн талбай, нөөцийг нэмэгдүүлдэг бөгөөд манай улс 1971 оноос уг арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн ба 1980-аас 2018 оны хооронд 199144.9 га талбайг ойжуулсан байна (Монгол орны байгаль, орчны төлөв байдлын тайлан 2018).

Зураг № 16. Монгол орны ойн тархалтын зураг



Монгол орны ойн нийт нөөц 1.2 тэрбум шоо метр бөгөөд үүний 78.7%-ийг шинэс, 9.3%-ийг хуш, 6.1%-ийг хус, 5.0%-ийг нарс, 0.23%-ийг гацуур, 0.02%-ийг жодоо, 0.2%-ийг улиас, 0.05%-ийг улиангар, 0.01%-ийг хайлаас, 0.28%-ийг бургас, 0.002%-ийг тоорой, 0.15%-ийг заган ойн нөөц тус тус эзэлж байна. Шилмүүст мод зонхилсон ойн дундаж нас 133.4 жил, 1га-ийн нөөц 151.3м³, өсөлт 1.13м³, навчит мод зонхилсон ойн дундаж нас 46.1 жил, 1 га-ийн нөөц 46.2м³, өсөлт 0.98м³, жилийн бүх дундаж өсөлт 10.1 сая м³ байна (Монгол орны байгаль, орчны төлөв байдлын тайлан 2018).


VII.1.1. Мод тарихын экологийн ач холбогдол

Агаарын бохирдлыг бууруулдаг байгалийн хамгийн чухал цэвэрлэх байгууламж бол ой мод юм. Ой мод нь дэлхийн шим салшгүй хэсгийг бүрдүүлж, манай гаргийн дулаарлын явцыг сааруулж хөрс, усыг тогтвортой байлгахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Нэг га ой мод сөөг нь 18 сая шоо метр агаарыг цэвэршүүлж, утаа униарын 35 хувь өөртөө шингээдэг. Ялангуяа навчит мод тоос шороог 20-70 хувь хүртэл өөртөө барьдаг байна.

VII.1.2. Мод, сөөг болон түүний бүтэц, зарим үүрэг

Мод нь үндэс, их бие, мөчир, навч гэсэн дөрвөн гол зүйлээс бүрдэнэ. Модны үндэс нь газрын хөрснөөс ус, чийг, эрдэс бодис, тэжээл авч их бие, навч мөчир рүүгээ дамжуулна. Мөчрүүд нь цэцэг навч болон үр жимс гаргана. Модны их бие нь холтсоор бүрхэгдсэн байдаг. Навч нь нарны гэрлийг хүлээн авах ба голдуу ногоон, улираас шалтгаалан шар, улаан гэх мэт өнгөтэй болох бөгөөд мөнх ногоон ч байдаг.

Зураг № 17. Модны үндсэн бүтэц



VII.1.3. Тарих тарих хугацаа

Монгол орны хувьд мод тарих хугацаа нь хаврын улиралд дөрөвдүгээр сарын 20-ноос тавдугаар сарын 25, намрын улиралд есдүгээр сарын 20-ноос аравдугаар 10-ны хооронд байдаг.

График 18. Мод тарьсан хугацаа



VII.1.4. Мод тарьсан аргачлал

Модны нүхийг ухаж бэлтгэхдээ угаас ул хөрстэй байдгийг харгалзан нүхний хэмжээг 40 см өргөнтэй, 50см-60см гүнтэй шуудуу ухаж бэлтгэв. Хуучин шороог хэрэглэлгүй суулгацын ургаж байсан үржил шимт хөрснөөс авчирч хийв. Учир нь хуучин бохир, үржил шимгүй, бүтцээ алдсан шороо, хөрсний үүрэг гүйцэтгэж шинэ суулгацыг цааш ургаж төлжихөд хангалттай шим тэжээл өгч чаддаггүй байна.

Мод тарих нүхэндээ 50 хувьд нь хар шороо, 30 хувьд нь элс, 20 хувьд нь хөх бууц сайтар хольж хөрсөө бэлтгэв. Бэлдсэн хөрсний гол хэсэгт модныхоо үндсийг тараан байрлуулж, шороогоор хучиж, шороог нягтруулж, агаар орохгүйгээр чигжив. Тарьсан модны үндэс нугалраагүй шулуун, үндэсний үзүүр доош чиглэсэн байх ёстойг анхаарав. Тарьц, суулгацыг нүхний ёроолд хэтэрхий гүн суулгагүй модны үндэсний хүзүү нүхний ирмэгийн төвшнөөс 10-15 см доор байрлуулав.

Мод, сөөгийг ургуулахад хамгийн чухал зүйл бол усалгаа юм. Шанагаар услах, хайрцаглах аргаар услах, тогоогоор услах гэх мэтийн аргууд бий. Модыг тарьсан өдөртөө 50-60 литр, сөөгийг 20-30 литр усаар услав. Усалгааг өглөө, орой хийдэг тогтмол хийж байв. Анх суулгасан модны иш орчим хэт даралттай усаар усалж бөгөөд усалгааг нүхний дотор талын ханыг дагуулан зөөлөн услав.

Зураг № 19. Уурхайн хотхонд тарьсан мод



VII.1.5. Мод суулгасныг дараах арчилгаа

Модны шилжүүлэн суулгасны дараа услах шаардлагатай. Модыг услах далд систем буюу хоолойг ашигла бороожуулах, ил систем буюу уламжлалт гаргуун усалгааны арга байдаг. Тарьсан суулгацаа гар аргаар хавар 7 хоногт 1-2 удаа нэг 30-50 л усаар усална.

Шилжүүлэн суулгасан мод бутанд салхины хор нөлөө эхний жилд маш их. Учир нь эхний жилд мод тухайн орчин хөрсөндөө сайтар “холбогдож барьцалдаж” өгөөгүй байдаг. Тухайн газартаа үндсээрээ бүрэн бэхжээгүй модыг салхи байнга ганхуулж хөдөлгөж байдаг нь тухайн модны үндэс гэмтэлд орж цаашид ургах боломжгүй байдаг. Салхи ба хаврын түлэгдэлтээс хагалгаж тулгуур бэхэлгээг хийж байв. Бэхэлгээг хийх арга олон янз бөгөөд олс, шургааг мод, зориулалтын бэхэлгээ байдаг. Тулгуур бэхэлгээг байнга шалгаж онцгой анхаарна.

Тарьсан модыг мал, мэрэгч амьтад туулай, оготно зэрэг сүйтгэдэг. Ялангуяа ойр орчимд мал байгаа газарт тарьж ургуулсан мод, бут тэдгээрийн малын хоол тэжээл болох эрсдэлтэй. Тиймээс уурхайн хотхоны орчимд малтай байгаа айл байгаа учир мод бутыг уурхайн хотхонд хашаанд тарив.

2024 онд модны тарьц суулгацыг уурхайн хотхоны тохижилт, ногоон байгууламж байгуулах гэсэн үндсэн зорилгоор нийт 2000 ш тарьц суулгацыг тариад байна.

Зураг № 20. Уурхайн хотхонд тарьсан мод



VII.1.6 Техникийн сэргээлтийн төлөвлөгөө

“Бэрх уул” ХХК нь уурхайн үйл ажиллагааны эхэн шат болох ашигт малтмалын хайгуул, ил уурхайн малталт, олборлолтын явцад хөндөгдсөн газрыг үйл ажиллагааны явцад тасралтгүй нөхөн сэргээж байхаар дотоод журам, менежментийн төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Чандган тал уурхайн нүүрсний нөөцийг хэсэглэлүүдийг бүрэн олборлож дуусаагүй тул 2023 онд ашиглалтын карьерт техникийн нөхөн сэргээлт хийхгүй.

Чандган тал уурхайн нөөцийг бүрэн олборлож дуусаагүй бөгөөд нүүрсний давхаргыг бүрэн олборлож дуустал техникийн нөхөн сэргээлтийг уурхайн ашиглалтын карьерт хийгүй. Ил уурхайн одоогийн хөрс хуулалтын түвшин +1148-р түвшинд байгаа бөгөөд уурхайн эцсийн хүрээ +1110 түвшин хүртэл уурхайн гүнзгийрэл 38м хүрэх юм.

Зураг 21. Ил уурхайн ашиглалтын хүрээ



**V. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА
ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ**

Уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй болзошгүй сөрөг нөлөөллийн үргэлжлэх эрчим ба цар хүрээг тогтоож, нөлөөллийг бууруулах буюу зайлсхийх, багасгах, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлсний дараа үлдэх нөлөөллийг дүйцүүлэн хамгаалахаар шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Хүснэгт 10. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, хэрэгжилт

№	2024 оны БОМТөлөвлөгөө			2024 оны БОМТөлөвлөгөөний биелэлт
	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хэрэгжилт
1.	Биологийн олон янз байдлыг сайжруулах менежментийн арга хэмжээг тодорхойлох	Тусгай зөвшөөрлийн талбайн гадан талд эзэн холбогдогчгүй эвдрэлд орсон талбайд нөхөн сэргээлт хийж байгаль хамгааллын үйл ажиллагаа явуулах.	Сумын нутагт	Уурхайн ашиглалтын талбайн ойролцоох хог хаягдал, малын сэг зэмийг цэвэрлэн эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийв.

Зураг 22. Уурхайн ашиглалтын талбайн ойролцоох малын сэг зэм, хог хаягдал



Зураг 23. Уурхайн ашиглалтын талбайн ойролцоох малын сэг зэм, хог хаягдал



Зураг 24. Малын сэг зэм, хог хаягдлыг цэвэрлэж нөхөн сэргээлт хийсний дараахи байдал



VI. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 11. Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний хэрэгжилт
1	Археологийн болон Палеонтологийн дурсгал	Төслийн талбайд хийлгэсэн судалгаагаар Археологийн болон Палеонтологийн олдвор илрээгүй бөгөөд боловч Уурхайн ашиглалтын явцад түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл “Соёлын өвийг хамгаалах тухай” хуулийн хүрээнд хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөөд байна.	Олборлолтын үед түүх соёлын биет өв илэрвэл тухайн олдворын хүрээнд	Ил уурхайн ашиглалтын явцад түүх соёлын дурсгалт зүйлс илрээгүй хэдий ч “Газрын хэвлийг ашиглах явцад геологийн ховор илэрц, эрдэсжилтийн онцгой тогтоц, солир, палеонтологи, археологийн болон шинжлэх ухаан, түүх, соёлын хувьд сонирхол татах бусад зүйл ил газрын хэвлийг ашиглагчид ажлаа зогсоож, энэ тухай төрийн зохих байгууллагад нэн даруй мэдэгдэх үүрэгтэй” гэсэн Монгол улсын хууль, тогтоомжуудыг үндэслэл болгон олборлолтын ажлыг гүйцэтгэж байна.

VII. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 12. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

№	2024 оны БОМТөлөвлөгөө			2024 оны БОМТөлөвлөгөөний биелэлт
	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний хэрэгжилт
1	Уурхайн ойролцоо нутаглаж, амьдардаг иргэд	Энэ ажлын хүрээнд ямар нэгэн ажил төлөвлөөгүй боловч Уурхайн ашиглалтын явцад нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох зайлшгүй шаардлага гарвал тухай бүр хэрэгжүүлэн ажиллана гэж төлөвлөсөн.	Уурхайн нөлөөлөлд өртсөн, нүүлгэн шилжүүлэх айл өрхийн хэмжээгээр	Энэ ажлын хүрээнд ямар нэгэн ажил хийгдээгүй болно.

VIII. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 13. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	2024 оны БОМТөлөвлөгөө			2024 оны БОМТөлөвлөгөөний биелэлт
	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт
1	Аянга буух	Аянга, цахилгаантай ширүүн бороотой, хүчтэй салхи шуургатай үед гадаах ажлыг түр зогсоох	Уурхайн эдэлбэр газарт	Цаг агаарын урьдчилан сэргийлэх болон онц аюултай үзэгдлээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, мэдээ, дохиог хэвлэл мэдээллийн хэрэгсэл, мэдээллийн бусад эх сурвалжаас тогтмол хүлээн авч дуу цахилгаантай ширүүн бороотой, хүчтэй салхи шуургатай өдөр ил уурхайн ажлыг түр зогсоов. 2024 оны 7-р сард усархаг ширүүн бороотой өдөр гадаах ажлыг түр зогсоосон.
	Гал түймэр	Төслийн талбай болон уурхайн хотхонд байршуулсан гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн бүрдлийг тогтмол шалгах. Бүх машин мехнизамд галын хор байршуулах. Гал түймрээс урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах тэмдэг, тэмдэглэгээ мэдээлэх самбар зэргийг байршуулах.	Ашиглалтын талбай болон уурхайн хотхон	Уурхайн талбайд гал түймэр, онцгой байдалд эрсдэлийг бууруулах чиглэлээр ажлын талбайд тогтмол ажлын байрны үзлэгүүд зохион байгуулж, гал түймэр гарч болзошгүй бүх цэгүүдэд гал сараа, унтраах,хэрэгслүүдийг бүрэн суурилуулсан. Гал түймэртэй тэмцэх болон Гамшгийн тухай хуулийн дагуу уурхайн талбайн барилга эрсдэлийн үнэлгээний дагуу, бүх хэсэг нэгжүүдэд онцгой байдлын үед ажиллах төлөвлөгөөг Уул уурхайн аврах ангиар батлуулан мөрдөн ажиллаж байна.
	Хүний эрүүл мэнд муудах	Хүний эрүүл мэнд муудахад тухайн нөхцөлд хамгийн тохиромжтой газар руу нүүлгэн шилжүүлэхийг ажлыг зохион байгуулна.	Уурхайн талбайд	Уурхайн нийт ажилчдын эрүүл мэндэд хяналт тавих шаардлагатай тохиолдолд эмлэлгийн тусламж үзүүлэх зорилгоор сумын эмнэлэгт үзлэг хийлгэж байна.

Хэнтий аймгийн Мөрөн сумын нутагт орших “Чандган тал” нэртэй талбайд
2024 онд хэрэгжсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Автомашины осол	Тээврийн хэрэгслийн жолоочид Замын хөдөлгөөний аюулгүйн дүрэм болон компанийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч сургалтыг зохион байгуулах.	Уурхайн талбай болон хүдэр тээврийн зам	МУ-ын холбогдох хууль тогтоомж, Замын хөдөлгөөний аюулгүй ажиллагааны дүрэм болон уурхайн аюулгүй ажиллагааны зааварчилгааны хүрээнд холбогдох аюулгүй ажиллагааны журмыг боловсруулан тогтмол мөрдөн ажиллаж байна.
-----------------	---	---	--

IX. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 14. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	2024 оны БОМТөлөвлөгөө			2024 оны БОМТөлөвлөгөөний биелэлт
	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт
1	Ахуйн	Хог хаягдлын эх үүсвэр бүрд хог хаягдлыг ангилан ялгаж хаях зориулалтын хогийн сав байрлуулах. Ангилсан хог хаягдлыг сумын төвлөрсөн хогийн цэгт хаях.	Уурхайн талбайд	Уурхайн талбайд үүсэж буй нийт хаягдлын ангилан ялгалтыг хэрэгжүүлснээр хаягдлын дахин ашиглалт, дахин боловсруулалтыг тогтмол нэмэгдүүлэн ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд үйл ажиллагаанаас үүссэн нийт хаягдлын 31 хувийг дахин ашиглалт болон дахин ашигласан байна. Дэлгэрэнгүйг тус тайлангийн IX дүгээр бүлгээс харна уу.
		Хог хаягдлыг кодчилсон жагсаалтын дагуу тухай бүрд нь хөтөлж, бүртгэх.	Уурхайн талбайд	2018 оны А/428 тоот тушаалын дагуу “Хог хаягдлын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журам”-д тусгагдсаны дагуу хог хаягдлын жилийн эцсийн тайланг орон нутгийн удирдлагад өгч байна.
2	Үйлдвэрийн	Хаягдал дугуйг өөрсдийн хэрэгцээнд дахин ашиглах, шаардлагатай бол орон нутгийн хэрэгцээнд өгөх	Уурхайн талбайд	<i>Дахин ашигласан</i> 1. Мод: 45 кг, 2. Жижиг дугуй: 3 ш, 3. Резин: 5 ш, 4. Шланк: 2 ш, 6. Бүтээлэг, эсгий: 4 ш, 7. Төмөр: 128 кг.
		Хэрэглэсэн шатах тослох материалыг УБ хотын Багахангай дүүрэгт “Ахуй мандал” хаягдал тос боловсруулах үйлдвэрт тушаах	Уурхайн талбайд	<i>Дахин боловсруулсан</i> Уурхайн нь аюултай хог хаягдлыг дахин боловсруулах чиглэлээр боломжит бүхий л хувилбарыг судлан ажилдаг бөгөөд тайлант

Хэнтий аймгийн Мөрөн сумын нутагт орших “Чандган тал” нэртэй талбайд
2024 онд хэрэгжсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

3	Аюултай	Одоогоор манай улсад аюултай, хортой хог хаягдал устгах үйлдвэр байхгүй байгаа учир Аюултай хаягдлыг “Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах” журмын хэрэгжилтийг хангаж ажиллана.	Уурхайн талбайд	хугацаанд 2024 онд үүссэн аюултай ангилалд хамаарах 1200 л ажилсан тос маслыг "Ахуй Мандал" дахин боловсруулах үйлдвэрт тушаав. <i>Хадгалж байгаа</i> 1. Ахуйн зай хураагуур: 35 ш 5. Принтерийн хор: 2 ш 6. Будаг 3 кг
---	----------------	--	-----------------	--

ХИ.1 Хог хаягдлыг бууруулах, дахин ашиглах, боловсруулах

Хог хаягдлын менежментийг амжилттай хэрэгжүүлэхийн үндэс нь ангилан ялгалт юм. Ангилан ялгаж байгаагийн давуу тал нь дахин ялгах шаардлагагүйгээр шууд дахин боловсруулах үйлдвэрт тушаах боломжтой болж байгаа явдал юм. Ангилан ялгахын тулд хог хаягдал гарах эх үүсвэр цэг бүрд тохирох төрлийн хогийн савнуудыг байрлуулав.

Уурхайн хотхонд ахуйн гаралтай хог хаягдлыг ангилан түр хадгалах хогийн саванд цуглуулав. Ахуйн болон хатуу хог хаягдлыг ангилсны дараа дахин ашиглах хатуу хог хаягдлыг тээвэрлэн хоёрдогч түүхий эд авдаг төвлөрсөн цэгт тушаахаар түр хадгалж байна.

Техникийн ашигласан тос маслыг битүүмжлэл сайтай саванд цуглуулан дахин боловсруулах үйлдвэрт тушаав. Бусад хатуу хог хаягдлыг ялган, зориулалтын саванд цуглуулан, тусгайлан тээврийн хэрэгслээр зөөж тогтоосон цэгт хаяв.

Төслийн талбайд үйлдвэрлэлийн бүхий л үе шатнаас гарах хог хаягдлыг хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх талаас анхаарч урьдчилан сэргийлэх, хязгаарлах, хамгаалах, дахин ашиглах арга хэмжээг төлөвлөж удирдлага зохион байгуулалтаар хангаж зохицуулан ажиллах нь чухал байдаг. Ингэснээр хог хаягдал үүсгэгч этгээд /ажилтан, албан хаагч, хэлтэс нэгж/-ийн хог хаягдлын зохистой хэрэглээг хэвшүүлснээр хүрээлэн буй орчны бохирдлоос сэргийлэх, төслийн үйл ажиллагааны уялдаа холбоонд эерэг үр дүнтэй.

ХИ.2. Ахуйн хог хаягдал

“Ахуйн хог хаягдал” гэж айл өрхөөс гарах энгийн хог хаягдлыг хэлнэ. Ахуйн хог хаягдлын эх үүсвэр бүрд хог хаягдлыг ангилан ялгаж, зориулалтын хогийн сав байрлуулан түр хадгалав. Ангилсан хог хаягдлыг сумын төвлөрсөн хогийн цэгт хаяв.

Төслийн хэмжээнд сард дунджаар 12 хүн ажилласан бөгөөд ажилчдын хоногт гаргах хуурай хаягдал нь хүнсний зүйл, үнс, яс, ногооны хаягдал гэх мэт 1 хүний хоногт гаргах хуурай хог хаягдлын хэмжээ 1.5 кг ба, хоногт нийт 10.5 кг, сард 315 кг хог гарч байв. Тус ахуйн гаралтай хог хаягдлын эх үүсвэр бүрд хог хаягдлыг ангилан ялгаж, сумын төвлөрсөн хогийн цэгт хаядаг.

ХИ.3. Аюултай хог хаягдал-техникийн тос

МУ-ын Хог хаягдлын тухай хууль “Аюултай хог хаягдал” гэж тэсрэмтгий, шатамхай, урвалын идэвхтэй, исэлдүүлэгч, агаар болон устай харилцан үйлчилж хортой хий ялгаруулдаг, халдвартай, идэмхий, хүн амьтанд богино болон удаан хугацаанд хортой нөлөөлөл үзүүлдэг, байгаль орчинд хортой шинж чанартай, устгасны дараа аюултай шинж чанартай ялгарал үүсгэдэг хог хаягдлыг хэлнэ гэж заажээ.

Чандган тал нь уурхайн нь үйл ажиллагаандаа химийн бодис хүргэлдэггүй бөгөөд талбай дахь аюултай хаягдлыг өөр хоорондоо холилдохгүй, хүрээлэн буй орчинд бохирдол үүсгэхгүй нөхцөлд түр хадгалдаг бөгөөд 2024 онд уурхай эхэлсэн цагаас хойш хуримтлагдсан нийт аюултай болон хяналттай ангиллын хаягдлын хэмжээ тайлант хугацааны байдлаар 1200 л техникийн тос хуримтлуулсан байна.

Зураг 25. Аюултай хог хаягдал-техникийн тос түр хадгалах цэг



Машин механизмын засвар үйлчилгээ тос маслыг солихдоо хөрсөнд тос масло асгарахаас сэргийлж цементэн засварын талбай дээр битүүмжлэл сайтай саванд хаягдал тосыг хуримтлуулдаг. Хаягдал тосыг уурхайн талбайд 1 цэг дээр цуглуулах бөгөөд эдгээр нь бусад энгийн болон аюултай хаягдалтай холилдохгүй цуглуулахаар төлөвлөгдсөн талбай байна. Уг талбайн шалыг цементээр цутгаж хаягдал тос хөрсөнд нэвчихээс сэргийлсэн. Тайлант хугацаанд нийт 1200 л тосыг дахин боловсруулагч Ахуй мандал үйлдвэрт нийлүүлэв.

Тус үйлдвэрт төрөл бүрийн автомашины хаягдал дугуй, резин, хуванцар, уул уурхайн техник хэрэгсэл болон автомашины хаягдал тос, тосол буюу ажилласан тосыг боловсруулж, чанар, стандартын шаардлага хангасан дизель түлш, бензин үйлдвэрлэлийг дотооддоо нэвтрүүлжээ. Дээр дурдсан хаягдал дугуй, резин, хуванцар, уул уурхайн техник хэрэгсэл авто машины ажилласан тос зэргийг шатааж, ил хаяхад байгаль орчныг маш ихээр бохирдуулдаг бөгөөд энэ төрлийн хог хаягдал нь аюултай хог хаягдалд тооцогддог. Тэгвэл уг үйлдвэр эдгээр хог хаягдлыг байгаль орчинд хоргүй технологиор дахин боловсруулж, байгаль орчинд ээлтэй хоёрдогч түүхий эд үйлдвэрлэж байна. Монголдоо үйлдвэрлэж буй дизель түлш нь евро-4 стандартын, тослог чанар, тетаны тоо өндөртэй тул авто машиныг илүү хүчтэй болгох, эд ангид сайн гэдгээрээ давуу талтай юм байна.

Зураг № 26. Ахуй мандал үйлдвэрт хаягдал тос тушаав



ХП.4. Бусад аюултай хог хаягдлыг хадгалах

Уурхайн хэмжээнд ерөнхий 2 төрлийн зай хураагуур хаягдал болдог бөгөөд ахуйн хэрэглээний жижиг хэмжээний зай хураагуур, авто техникийн том оврын зай хураагуурыг CU, GS25 д байгаа ашигласан батарей хадгалах хогийн саванд хаяв.

Эмнэлгийн хаягдал: Эмнэлгийн хаягдлыг уурхай дээр үүсгэдэггүй бөгөөд шаардлагатай тариа, боол зэргийг Мөрөн сумын эмлэг дээр боол болон тариаг хийлгэж байна. Мөрөн сумын эмнэлэг эмнэлгийн хаягдлыг уураар ариутгах төхөөрөмж буюу Хятад улсын сүүлийн үеийн GB8599- 2008, америк улсын FDA болон EN285, EC/97/23 стандартад тэнцсэн автоклаваар ариутган халдваргүйжүүлэн устгаж байна.

Хүснэгт 15. 2023 оны хог хаягдлын эх үүсвэрийн тооллогын хуудас

Аймаг, нийслэл	Хэнтий	Улсын бүртгэлийн дугаар	
Сум, дүүрэг	Мөрөн	Регистрийн дугаар	2643928
Аж ахуй нэгжийн нэр	Бэрх уул ХК	Үйл ажиллагааны чиглэл буюу хог хаягдлын бүлэг	Уул уурхайн

№	Хог хаягдлын бүлгийн код	Дэд бүлгийн код	Хог хаягдлын дэд бүлэг	Хог хаягдлын төрлийн код	Хог хаягдлын төрөл	Аюулын зэрэг	Сард үүсэх хэмжээ /кг, тн, м³, л, ш/	Хаана хядаг				Хадалдаж байгаа хэмжээ/тн, м³, л, ш/	тайлбар
								Хогийн цэг	Бохир усны хүх	Боловсруулах үлдвэр	Дахин ашигладаг		
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
1	Б	Б 01	Хөдөө аж ахуй, цэцэрлэгжүүлэлт, усны аж ахуй, ойн аж ахуй, загасны аж ахуй, ан агнуурын аж ахуй	Б 01 06	Мод бэлтгэлээс үүссэн хаягдал		50 кг				тийм		
2	М	М 05	Шингэн түлшний хаягдал	М 05 01	Түлшний тос, дизель	А	1200 л			тийм		1200 л	Хаягдал тосыг Ахуй мандал үлдвэрт тушаадаг.

Хэнтий аймгийн Мөрөн сумын нутагт орших “Чандган тал” нэртэй талбайд
2024 онд хэрэгжсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

3	О	О 01	Сав баглаа боодол (ангиалан ялгасан ахуйн сав баглаа боодлын хаягдал орно)	О 01 02	Хуванцар сав баглаа боодол		10 кг					10 кг	Хуванцар савыг битүү вагончигт түр цуглуулж байгаа.
4	Ө	Ө 01	Бусад хог хаягдал	Ө 01 04	Ашиглалтаас гарсан машин, механизм, тэдгээрийг задлах болон засварлах үйл ажиллагаанаас үүсэх хаягдал	А	3 ш					15 ш	Хог хаягдал түр хадгалах вагончигт цуглуулж байгаа.
5	Ө	Ө 01	Бусад хог хаягдал	Ө 01 14	Ашиглалтаас гарсан машин, механизм, тэдгээрийг задлах болон засварлах үйл ажиллагаанаас үүсэх хаягдал		40 кг				Тийм	2 тн	
6	Ө	Ө 06	Батарей, аккумулятор	Ө 06 01	Хар тугалгатай аккумулятор	А	35 ш				Тийм	35 ш	Хар тугалгатай аккумулятор УБ хотод цэнэглүүлээд дахин ашигладаг. Батарей 30ш хадгалж байгаа.
7	Т	Т 03	Бусад ахуйн хог хаягдал	Т 03 01	Холимог ахуйн хог хаягдал		200 кг	200 кг					Сумын хогийн цэгт хаядаг.

Х. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

Х.1. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

Тухайн төслийг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг “орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” гэдэг. Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль хамгаалах үүргээ сахин биелүүлэхийн тулд орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд мэргэжлийн байгууллагатай гэрээ хийж, ус, агаар, хөрсний шинжилгээг хийлгэсэн.

Хүснэгт 16. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилт

№	2024 оны БОМТөлөвлөгөө			2024 оны БОМТөлөвлөгөөний биелэлт
	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилт
1	Агаарын чанар			
	СО (Нүүрстөрөгчийн дутуу исэл) NO ₂ (Азотын давхар исэл) SO ₂ (Хүхэрлэг хий) Тоос (PM ₁₀ , PM _{2.5}) Дуу шуугиан	1. Тээврийн гол замын орчим, зайн алслагдмал салхин доод талд 2. Ил уурхайн талбай 3. Уурхайн тосгон	5, 9-р сард жилд 2 удаа. Үйл ажиллагаа явагдаж байгаа үед хийх	Мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан уурхайн талбайд дөрвөн байршилд агаарын бохирдуулагч зарим хийн хэмжилт хийлгэв. Тус тайлангийн хавсралтаас харна уу.
2	Хөрсөн бүрхэвч			
	Хөрсний механик бүрэлдэхүүн хими, физикийн шинж чанар Нефтийн бүтээгдэхүүн Хүнд металл Pb, Cd, Hg, Cr, Zn, Co,	1. Автомашины зогсоол 2. Хог хаягдлын талбай 3. ШТМ-ын агуулах 4. Ил уурхайн талбай 5. Нөлөөллийн бүсээс гаднах талбай буюу хяналтын цэг	5, 9-р сард жилд 2 удаа. Үйл ажиллагаа явагдаж байгаа үед хийх	Мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан хөрсний хүнд металлын үзүүлэлтүүдийг шинжлүүлсэн. Шинжилгээгээр хөрсөн дэх хүнд металлын агууламж MNS5850:2019 стандартын шаардлагыг бүрэн хангаж байна. Тус тайлангийн хавсралтаас харна уу.
3	Ус орчин			
	Анион, катион Ерөнхий үзүүлэлтүүд Бактериологи Хүнд металл Hg, As, Co, Pb, U, Cu, CN, Zn	Ундны уснаас, ойр орчмын худгаас	5, 9-р сард жилд 2 удаа. Үйл ажиллагаа явагдаж байгаа үед хийх	Уурхайн ундны уснаас болон ойр орчмын худгаас усны хими болон физикийн үзүүлэлтийг лабораторид шинжлэхэд усны шинжилгээний хариу “MNS 0900 : 2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ стандарт

Хэнтий аймгийн Мөрөн сумын нутагт орших “Чандган тал” нэртэй талбайд
2024 онд хэрэгжсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

				шаардлагад нийцэж байсан. Тус тайлангийн хавсралтаас харна уу.
4	Амьтан			
	Амьтдын зүйлийн бүрэлдэхүүн, тоо толгой (нягтшил), тархалт, байршил, шилжилт хөдөлгөөн	Төслийн талбай, түүний ойролцоо	Үйл ажиллагааны турш	Чоно, Үнэг, Хярс, Цагаан зээр зэрэг ан амьтан, Талын бүртгэд, Тас, Идлэг шонхор зэрэг жигүүртэн, Алагдаахай, Оготно /, Бозлог зэрэг мэрэгчид амьдардаг. Уурхайн бүх ажилчдад зайлшгүй авах ёстой сургалтад хууль бус ан агнахгүй байх талаар сургалтад зайлшгүй хамрагддаг. Ажилчдад зориулан уурхайн орчмын ховор, нэн ховор амьтдын талаар мэдээлэл агуулсан танилцуулга хийсэн.
5	Ургамлын нөмрөг			
	Ургамлын төрөл зүйл, бүрхэц %, бодгиалиудын тоо, Ургамлын дундаж өндөр, газрын гадаргуугаас дээшхи ургамлын биомасс, кг/га гэх мэт.	Тусгай зөвшөөрөлтэй талбай болон төслийн нөлөөллийн талбай	Ургамлын хяналт шинжилгээг мониторингийн 3-5 цэгт	БОНУТ-н ургамлын бичиглэлээр уурхайн тусгай зөвшөөрлийн талбайд нийт 18 овог, 47 төрөл, 67 зүйл ургаж байгаагаас 26 зүйл бэлчээрийн (38.81%), 26 зүйл эмийн ашигт ургамал (38.81%), 21 зүйл хөл газрын ургамал (31.34%) бүртгэгдэж байна. Тус талбай дотор 11 зүйл нэг наст өвслөг ургамал (16.42%), 52 зүйл олон наст өвслөг ургамал (77.61%), 4 зүйл сөөг, заримдаг сөөгөнцөр ургамал (5.97%) ургаж байгаагийн дотор нэн ховор, ховор, унаган, үлдвэр ургамлын бүртгэлийг гаргахад нэн ховор ургамал Монгол алтанхундага (<i>Adonis mongolica</i> Simonovicz.), ховор ургамал бүртгэгдээгүй, Монголын унаган ургамал Цагаан хунчир (<i>Astragalus galactites</i> Pall.) 1 зүйл, Монголд байгаа завсарын унаган ургамал Жижиг навчит харгана (<i>Caraganamicrophylla</i> (Pall) Lam.) бүртгэгдсэн.

XI. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Чандган тал уурхай нь орон нутаг болон аймгаас санаачилж зохион байгуулж байгаа аливаа ажил, өдөрлөгт идэвх санаачилгатай оролцдог. Байгаль орчны асуудал нь зөвхөн байгаль орчны ажилтан, мэргэжилтнүүд анхаарал хандуулах биш захирлаас эхлээд тогооч, цэвэрлэгч, жолооч гээд уурхайн бүхий л ажилтнуудын анхаарал хандуулах чухал асуудал юм. 2024 онд “Бэрх уул” ХК-ны удирдлагын зүгээс дараах ажлуудыг хэрэгжүүлэв.

ҮҮНД:

1. Компанийн зүгээс байгаль орчин менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд анхаарч төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллав.
2. Байгаль орчны нарийвчилсан үнэлгээг “Ашид таван эрдэнэ” ХХК хийлгэсэн.

XI.1. БОМТ-ний төсвийн нэгтгэл

Хүснэгт 17. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний төсвийн нэгтгэл

Д/д	Хөрөнгийн зориулалт	Хэмжих нэгж	Төлөвлөсөн зардлын хэмжээ /төгрөг/	Хугацаа
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	төгрөг	10,860,0000	2024 он
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	төгрөг	1,500,000	2024 он
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	төгрөг	250,000	2024 он
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	төгрөг	×	×
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	төгрөг	×	×
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	төгрөг	1,300,000	2024 он
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	төгрөг	1,600,000	2024 он
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	төгрөг	750,000	2024 он
9	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	төгрөг	500,000	2024 он
10	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	төгрөг	500,000	2024 он
	Дүн		17,200,000	